


1



Ариутгагч бодис ашиглан жолоочийн бүхээг болон зорчигчийн салоныг өдөрт хэд хэдэн удаа цэвэрлэж байх. Ялангуяа, хаалганы бариулны дотор гадна тал, жолооны хүрд, хяналтын самбарыг сайтар цэвэрлэх. Зорчигчийн салоныг цэвэрлэхдээ бариул, толгойн болон гарын түшлэгийг мөн сайтар цэвэрлэж байх.

2



Зогсох бүртээ зорчигчийн салоныг агааржуулж байх. Хэрэв цаг агаар тохиромжой байвал агааржуулагч (air conditioner) болон халаагч (паар)-ийг ашиглахгүйгээр зорчигчийн салоны цонхыг онгорхой байлгах.

3



Гараа усаар эсвэл шингэн савангаар 30 секундын турш сайтар угаах. Машиндаа суух, буух болон цэвэрлэгээ хийсний дараа гараа байнга халдваргүйжүүлэх.

4



Зорчигчийн тасалбар болон бэлэн мөнгөтэй харьцахдаа бээлий өмсөх.

5




Чухал шаардлага гараагүй тохиолдолд машины бүхээгнээс гарахгүй байх. Хэрэв зорчигчтой харьцах шаардлага гарвал маск зүүж, бээлий өмсөх.

6



Зорчигчидтой аль болох хол зайнаас харьцах. Ойрхон харьцах шаардлага гарвал маск зүүж, бээлий өмсөх.

7



Зорчигчдод өөр хоорондоо дор хаяж нэг метрийн зайнаас харьцах тухай сануулах.

8



Ханиах, найтаалгах (агаар дуслын замаар) болон шууд контактаар вирус тараахаас сэргийлэх.

9



Хэрэв та эсвэл таны гэр бүлийн гишүүдэд хуурай ханиах, халуурах гэх зэрэг COVID-19-н шинэ тэмдэг илэрвэл байгууллагынхаа менежерт яаралтай хандах.

10



Эрүүл мэндийн байгууллага болон өөрийн компанийн зүгээс өгсөн заавар, журмыг чанд мөрдөх.

Хариуцлагатай байх



QR кодыг уншуулан олон улсын тээвэртэй холбоотой мэдээллийг авна уу.

